



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Тавантолгой

ХУРЛЫН ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

“Тавантолгой” ХК-ий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргын саналыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Ө.Баянмөнхийг “Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
даргаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.МӨНХБАЯР



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 02

Тавантолгой

**2018 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.14, 63 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуралд оролцогчдын 100%-ийн саналаар баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг компаний бодлого, шийдвэрт тусгаж хэрэгжүүлж ажиллахыг компаний Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.БАЯНМӨНХ



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 03

Тавантолгой

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дүгээр хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батласугай.

2. “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор “Тавантолгой” ХК-ий уурхайд үүссэн хүндрэлийг багасгах, компаний засаглал, менежментийг сайжруулах, уурхайн тосгоныг нүүлгэх асуудлаар санал боловсруулж Өмнөговь аймгийн ИТХ-д танилцуулж шийдвэрлүүлж ажиллахыг орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж буй ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Р.Сэддоржид даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.БАЯНМӨНХ



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 04

Тавантолгой

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.15-р заалт, 76-р зүйлийн 76.1.12-р заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн ногдол ашгийг нэгж хувьцаанд 853 \найман зуун тавин гурван\ төгрөгөөр тооцож хуваарилахыг хуралд оролцогчдын 100%-ийн саналаар зөвшөөрсүгэй.

2. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал Р.Сэддоржид үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.БАЯНМӨНХ



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 05

Тавантолгой

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дугаар хэсгүүд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийг 451892400 \дөрвөн зуун тавин нэгэн сая найман зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун\ төгрөгөөр батласугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.БАЯНМӨНХ



ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 06

Тавантолгой

**ТӨЛӨӨЛӨН УДИРДӨХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүнээр:

- | | |
|------------------|----------------------------|
| 1. Ө.Баянмөнх | /54320362 ширхэг саналаар/ |
| 2. В.Мөнхбат | /54322384 ширхэг саналаар/ |
| 3. Б.Эрдэнэ-Очир | /54499858 ширхэг саналаар/ |
| 4. Д.Бат-Эрдэнэ | /44183986 ширхэг саналаар/ |
| 5. Д.Дагвадорж | /37415140 ширхэг саналаар/ |
| 6. С.Мөнхжаргал | /64898290 ширхэг саналаар/ |

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- | | |
|------------------|----------------------------|
| 1. Д.Батзориг | /40927860 ширхэг саналаар/ |
| 2. Э.Өлзийжаргал | /41023046 ширхэг саналаар/ |
| 3. Т.Тэгшээ | /72869104 ширхэг саналаар/ |
- нарыг тус тус сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.БАЯНМӨНХ